



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
БАЯНЗҮРХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/47

Алтрага

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Засгийн газрын 62 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2024 оны А/154 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хорогдсон мал, амьтны сэг зэмийг шатаах, булах аргаар устгах, химийн аргаар халдваргүйжүүлэлт хийх, бохирлогдсон бэлчээр, малын хашаа хороо, өтөг бууц, уст цэг, өвөлжөө, хаваржааны орчныг цэвэрлүүлэх, шаардлагатай бусад ажлуудыг хамтран зохион явуулахыг харьяа багийн Засаг дарга, мал эмнэлгийн ажил үйлчилгээ эрхлэх ААН-ийн захирал, дарга (Л.Дүүжий, Б.Тунгалагтуул), малчдын нөхөрлөлийн ахлагч нарт үүрэг болгосугай.

2.Хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ, ариутгал халдваргүйтгэл хийх ажилд зориулж олгосон хөрөнгийн хуваарийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3.Ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажилд шаардагдах зардлыг санхүүжүүлж, олгохыг сумын Санхүүгийн албаны дарга (А.Дэлгэрмаа), нягтлан бодогч (Э.Ариунаа)-нарт зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Л.Чимэдцэрэн), Мал эмнэлгийн улсын байцаагч (Ж.Даваажав) нарт үүрэг болгосугай.

ДАРГА  Г.ОДСЭР

6729010104